



**НИЙСЛЭЛИЙН  
СҮХБААТАР ДҮҮРГИЙН  
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ АЛБА**

Денверийн гудамж-13, 11 дүгээр хороолол,  
7 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг,  
Улаанбаатар хот, 14190  
Утас: (976) 7010 7632  
Цахим шуудан: SBD.KHAAA@sbd.gov.mn  
Цахим хуудас: www.sbd.ub.gov.mn

2024.03.22 № 36

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

СБДХААА/20240101051 дугаартай 11, 13, 17, 19, 20-р хороодод гэрэлтүүлэг хийх ажилд ирсэн тодруулгуудын хариуг хүргүүлж байна.

Тодруулга 1: ТШЗ 18.1-д заасан “харилцагч банк тус бүрээс хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн өргүй талаарх тодорхойлолтыг ирүүлнэ” гэсэн байна уг тодорхойлолтыг bigenscore.mn сайтаас авсан тодорхойлолтыг хүргүүлж болохуу эсвэл заавал банк тус бүрээс албан тоот авах шаардлагатай юу.

Тодруулгын хариу: bigenscore.mn сайтаас авсан зээлийн өргүй тухай тодорхойлолтыг үнэлгээнд харгалзан үзнэ.

Тодруулга 2: Өгөгдлийн хүснэгтний ТШЗ 19.1 д заасан 4. Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагыг нотлох гэрээний мэдээллийн Гэрээний хуулбар, акт, тодорхойлолт зэргийг заавал нотариатаар батлуулах шаардлагатай юу. Энэ нь үнэлгээнд нөлөөлөх үү.

Тодруулгын хариу: ТШЗ 17.2 -т заасан хугацаанд гэрээгээр гүйцэтгэсэн ажлын ижил төстэй ажилд тооцуулахаар санал болгосон гэрээт ажлын гэрээ, ажил хүлээлгэж өгсөн улсын комиссын акт, гүйцэтгэл нь бүрэн чанартай байсан талаарх өмнөх захиалагчийн тодорхойлолт зэрэг баримт бичгийн хуулбарыг нотариатаар гэрчлүүлэн ирүүлнэ. гэснийг ТШЗ 18.2 -т заасан хугацаанд гэрээгээр гүйцэтгэсэн ажлын ижил төстэй ажилд тооцуулахаар санал болгосон гэрээт ажлын гэрээ, ажил хүлээлгэж өгсөн улсын комиссын акт, гүйцэтгэл нь бүрэн чанартай байсан талаарх өмнөх захиалагчийн тодорхойлолт зэрэг баримт бичгийн хуулбарыг ирүүлнэ гэж залруулав.

Тодруулга 3: Тендерийн баримт бичиг болон өгөгдлийн хүснэгтэнд байгаа СБДХААА/202412051 дугаар эсвэл дахин зарлагдсан тендер шалгаруулалтын дугаар болох СБДХААА/20240101051 хоёрын алийг нь цаашид албан тоотдоо ашиглах вэ?

Тодруулгын хариу: Тендерийн баримт бичгийн СБДХААА/202412051 гэсэн дугаар нь албаны төлөвлөгөө батлагдах үед системээс олгогддог бөгөөд Төрийн худалдан авах ажиллагааны цахим сайтад нийтлэгдэх үед БДХААА/20240101051 гэсэн тендер шалгаруулалтын код дахин олгогддог. Иймд цаашид албан тоотдоо СБДХААА/20240101051 гэсэн тендер шалгаруулалтын кодыг ашиглана уу.

Тодруулга 4: ТШЗ 19.1 4. д заасан Ижил төстэй гэрээний туршлага: [ТШЗ 18.2-т заасан хугацаанд жил тус бүр батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн [100] хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажил тусгай зөвшөөрлийн хүрээнд гүйцэтгэсэн байх.] Энэ нь нэг ажил байх уу. эсвэл тухайн онд хийсэн ажлын нийт дүн байж болох уу. 2023 онд Гэрэлтүүлгийн 200 орчим саяаар 3 ажил хийсэн энэ

шаадлага хангах уу.

Тодруулгын хариу: ТШЗ 19.1 4. д заасан Ижил төстэй гэрээний туршлага: 2022 он, 2023 он тус бүр батлагдсан төсөвт өртөг /500 сая төгрөг/-ийн 100 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлыг тусгай зөвшөөрлийн хүрээнд нэг удаагийн гэрээгээр гүйцэтгэснийг үнэлгээнд тооцно.